

МОНГОЛ УЛС

Баталгаажуулалтын тайлан
Тогтвортой хөгжлийн стратегийн ажлын хэсэг (ТХСАХ)
Хараат бус баталгаажуулагч
2016 оны 10 сарын 10

1. ҮНДЭСЛЭЛ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС)-ыг хэрэгжүүлж, олон тооны олон тооны аж ахуйн нэгж, байгууллагын тайланг ил тод болгосон анхдагч орнуудын нэг нь Монгол улс юм. Монгол улсын ОУИТБС-ын тайланд байгаль орчны сан, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад хандивласан хөрөнгийг тусгадаг. Монгол улс улс төрийн хувьд тогтворгүй байгаа боловч онлайн мэдээллийн портал байгуулах зэргээр мэдээллийг аль болох нээлттэй болгохыг хичээж байна. ОУИТБС-ын Удирдах зөвлөл 2016 оны 6 сарын 12-ны хуралдаанаасаа 2016 оны 7 сарын 1-ээс эхлэн ОУИТБС-ын стандартыг ашиглан Монгол улсын баталгаажуулалтыг хийлгэж байх шийдвэр гаргасан билээ. Баталгаажуулалтын удирдамжийн дагуу Ажлын албанаас анхдагч мэдээллийг цуглуулж, оролцогч талуудтай зөвлөлдөн, ОУИТБС-ын шаардлагын дагуу (“Анхны үнэлгээ”) баталгаажуулалтын эхний үе шатыг хийж гүйцэтгэлээ. Тогтвортой хөгжлийн стратегийн ажлын хэсгээс томилсон хараат бус баталгаажуулагч нь ажлын албаны үйл ажиллагаа Баталгаажуулалтын гарын авлагад заасны дагуу хэрэгжиж байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өглөө. Ажлын хэсэг нь Анхны үнэлгээтэй танилцаж, шаардлагатай өөрчлөлтийг хийн, анхдагч тайлангийн дүгнэлтийг нэгтгэн ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хүргүүлсэн болно.

- **Хараат бус баталгаажуулагчийн гүйцэтгэсэн ажил**

Ажлын алба нь Монгол болон өөр дөрвөн улсын баталгаажуулалтын тайланг 10-р сарын сүүлээр Астана хотод болох Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр болсон билээ. Эдгээр орнуудын баталгаажуулалтын тайланг PDF форматаар засаж болох эх файлын хамт 2016 оны 9-р сард Тогтвортой хөгжлийн стратегийн ажлын хэсгийн Баталгаажуулалтын багт хүргүүлсэн юм. Ажлын албаны Анхны үнэлгээний тайланд Монгол улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, “Төлсөн авснаа нийтэл” эвсэл, Олон талт ажлын хэсгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Намжилдоржийн Энхбаяр нарын санал зөвлөмжийг тусгасан болно. Баталгаажуулалтын баг нь (1) ажлын хэсгийн бэлтгэсэн ОУИТБС-ын тайланд дүгнэлт хийж, (2) олон талт асуудал хариуцсан мэргэжилтэн 1, 7-р шаардлагад дүгнэлт хийж, зөвлөмж өгөн, (3) санхүүгийн мэргэжилтэн 2-6-р шаардлагад дүгнэлт хийж, зөвлөмж өгөн, (4) ажлын хэсгийн ахлагч зохион байгуулалтын ажлыг хариуцаж, тайлан бичих ажлыг удирдлаа.

- **Үнэлгээ хийхэд тулгарсан бэрхшээл**

Монгол улсын ОУИТБС-ын хэрэгжилтийг дүгнэх цаг хугацаа маш бага байсан нь баталгаажуулалтын багийнхны хувьд томоохон бэрхшээл байлаа. Оролцогч талуудтай тэр бүр уулзах боломж бага учраас Анхны үнэлгээнд тусгасан асуудлын хүрээнээс гарах боломж хязгаарлагдмал байв. Гэхдээ, хараат бус үнэлэгч нь мэдээлэл цуглуулах, оролцогч талуудтай зөвлөлдөх зэрэг Ажлын албаны хийсэн ажлыг давхар гүйцэтгэх үүрэггүй болохыг тэмдэглэх хэрэгтэй. Түүнчлэн Удирдах зөвлөлийн түргэвчилсэн удирдамжийн дагуу 2016 оны 7 сарын 1-ээс хойшхи үйл ажиллагааг үнэлгээнд оруулахгүй. Ийм бэрхшээлүүд байсан хэдий ч баталгаажуулалтын баг нь ажлын албанаас гаргасан Анхны тайланг нарийн судалж, Монгол улсад 2016 оны стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж өгсөн болно.

- **Анхны үнэлгээнд өгөх санал, зөвлөмж**

Баталгаажуулалт хийх удирдамжийн дагуу анхдагч мэдээ баримтыг цуглуулж, оролцогч талуудтай зөвлөлдөн Анхны үнэлгээг бичих ажлыг гол төлөв Ажлын алба гүйцэтгэсэн байна. Үүний дараа 2016 оны 6 сарын 4-17-ны хооронд холбогдох баримт бичгийг үзэж судлан, 2016 оны 7 сарын 6-8-ны хооронд дөрвөн хүнтэй ажлын хэсэг Монгол улсад ирж ажилласан нь 2016 оны 7 сарын 15-16-нд зохион байгуулсан Ази, Европ (АСЕМ)-ын Дээд түвшний 11-р уулзалтын өмнө 2016 оны 7 сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулсан Ази, Европ түмний чуулга, Иргэний нийгмийн байгууллагуудын уулзалттай давхцлаа. Энэ үеэр иргэний нийгмийн байгууллагууд Улаанбаатарт болж байгаа хурал, чуулганд оролцоод завгүй байсан учраас Монголын иргэний нийгмийн байгууллагууд, хөгжлийн түнш зэрэг зарим оролцогч талуудтай уулзалтын цаг тогтоход бэрхшээлтэй байв. Ялангуяа бүх уулзалт Улаанбаатар хотод болж байсан учраас хөдөө орон нутагт уулзалт хийх боломж хязгаарлагдмал. Энэ удаагийн томилолт 2016 оны 6 сарын 29-нд болсон Улсын их хурлын сонгуулийн дараа болсон бөгөөд Монгол улсад энэ үеэр Засгийн газрыг байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх ажил явагдаж байв. Ажлын албанаас нилээд олон хүмүүстэй уулзуулсан бөгөөд үүнд Олон талт ажлын хэсэг, хараат бус нэгтгэгч, олон талт ажлын хэсэгт төлөөлөл нь ажилладаг талууд, олон талт ажлын хэсэгтэй шууд хамтран ажилладаг байгууллага, хүмүүстэй уулзлаа. Түүнчлэн ажлын албанаас ОУИТБС-ын үйл явцад *оролцдоггүй* талуудтай уулзуулсан юм. Дээр дурьдсан бэрхшээл хэдий байсан ч ажлын албанаас хөдөө орон нутагт 3 өдрийн томилолт зохион байгуулж, бүх салбарыг төлөөлсөн олон тооны төлөөлөгчидтэй уулзлаа. Ажлын албанаас гаргасан анхны үнэлгээний тайлангийн бүтэц зохион байгуулалт сайн, уншиж ойлгоход хялбар байв. Тайланд баримт материал, оролцогч талуудын санал зөвлөмжийг бүрэн тусгаж, сайн дүн шинжилгээ хийсэн байна.

2. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- **ОУИТБС-ын хэрэгжилт**

Монгол улс ОУИТБС-ын есөн тайлан гаргажээ. Үүнд 2006–2014 оны санхүүгийн жилд газрын тос, байгалийн хий, нүүрс олборлолын чиглэлээр ажилладаг 1198 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, 2013 оны санхүүгийн жилд уул уурхайн компаниуд оролцсон байна. Монгол улс одоо 2015 оны санхүүгийн жилийг хамарсан 10 дахь тайлангаа бэлтгэж байна. Ажлын албаны үнэлгээнд дурьдсанаар “Монгол улсын ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй эхний үе шатыг хүртээмжтэй, цаг хугацааны хувьд тохиромжтой үе гэж тодорхойлж болно. Сүүлийн жилүүдэд, ялангуяа 2012 оноос хойш Олон талт ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүдийн оролцоо нэмэгдэж байна” гэж үзжээ.

Монгол улс олон тооны аж ахуйн нэгж, компаниудыг оролцуулж, байгаль орчны сан, орон нутагт шилжүүлсэн хөрөнгийг тусгах зэргээр тайлангийн хамрах хүрээг өргөжүүлж чадлаа. Түүнчлэн, орон нутагт ОУИТБС-ын салбар зөвлөлүүдийг байгуулж, ОУИТБС-ын онлайн мэдээллийн порталыг байгуулжээ. Харин төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит улсын үйлдвэрийн газруудаас ирүүлж байгаа төсвийн шинжтэй санхүүгийн зарцуулалт, засгийн газрын санхүүгийн харилцаа, гуравдагч эдгээдийн санхүүжилт зэрэг мэдээллийн чанар, дэлгэрэнгүй байдалд анхаарах хэрэгтэй байна.

- **ОУИТБС-ыг хэрэгжүүлсэн үр дүн, нөлөө**

Монгол улс ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр олон нааштай үр дүн гарсан байна. Ажлын албаны Анхдагч үнэлгээнд оролцсон орон нутгийн засаг захиргааны байгууллага, орон нутгийн иргэний нийгмийн төлөөлөл, оролцогч талууд ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгж, компаниудын хандлага өөрчлөгдсөн болохыг тэмдэглэжээ. “Өмнө нь орон нутгийн хүн амд нөлөөлөх нөлөөллийг төдийлөн анхаардаггүй байсан компаниуд одоо

тэдний хэрэгцээ, сонирхолд анхаарч, илүү хүндэтгэлтэй ханддаг болсон. Орон нутгийн хүн ам аймаг, суманд хичнээн тусгай зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг авах бүрэн боломжтой болсон бөгөөд энэ төрлийн мэдээлэл өмнө нь зөвхөн Засаг даргад л нээлттэй байв.” Засгийн газрын ажилтан орлого, зарлагыг нээлттэй болгосноор хөрөнгө оруулалтын орчин сайжирч, орон нутгийн хүн амтай харьцах итгэлцлийг нэмэгдүүлэн, тухайн орон нутагт ажиллах аж ахуйн нэгж байгууллагуудад нийгмийн тусгай зөвшөөрөл олгож эхэлснийг тэмдэглэн хэлэв.

- Хараат бус баталгаажуулагчийн үнэлгээ

Хүснэгт 1 – Баталгаажуулагчийн үнэлгээ

ОУИТБС-ийн шалгуур		Ахиц					Тэмдэглэл
		Ахиц гараагүй	Хангалтгүй	Тодорхой хэмжээнд ахиц гарсан	Хангалттай	Маш сайн	
Ангилал	Шалгуур						
Олон талт ажлын хэсгийн тухай	Засгийн газрын оролцоо (#1.1)				←		1
	Салбарын оролцоо (#1.2)						
	Иргэний нийгмийн оролцоо (#1.3)						
	Олон талт бүлгийн засаглал (#1.4)						
	Ажлын төлөвлөгөө (#1.5)						
Тусгай зөвшөөрөл, гэрээ	Хууль эрх зүйн орчин (#2.1)						
	Тусгай зөвшөөрөл олгох (#2.2)						
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл (#2.3)						
	Гэрээг нээлттэй болгох бодлого (#2.4)						
	Бенефициар өмчлөл (#2.5)						
Төрийн оролцоо (#2.6)							
Мониторинг	Олборлолтын мэдээ (#3.1)						
	Үйлдвэрлэлийн мэдээ (#3.2)						
	Экспортын мэдээ (#3.3)				←		2
Орлого цуглуулалт	Цогц байдал (#4.1)						
	Сайн дурын орлого (#4.2)						3
	Бартерийн гэрээ (#4.3)						
	Тээвэрлэлтийн орлого (#4.4)						
	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын гүйлгээ (#4.5)				→		
	Орон нутагт төлсөн шууд төлбөр (#4.6)						4
	Задаргаа (#4.7)						
	Мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлсэн эсэх (#4.8)						
	Мэдээллийн чанар (#4.9)						
Орлого хуваарилалт	Орлогын удирдлага ба зарцуулалт (#5.1)						
	Орон нутаг руу шилжүүлэх (#5.2)						
	Орлогын хуваарилалт (#5.3)						
	Заавал зарцуулах нийгмийн зардал (#6.1.a)						

Нийгэм, эдийн засгийн Socio-economic contribution	Сайн дураар хандивлаж буй нийгмийн зардал (#6.1.b)						
	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын төсвийн шинжтэй санхүүгийн зардал (#6.2)						
	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр (#6.3)						5
Үр дүн, нөлөөлөл	Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)						
	Тоо, мэдээллийн олдоц, хүртээмж (#7.2)						6
	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал (#7.3)						
	Хэрэгжилтийн үр дүн, нөлөөлөл (#7.4)						

Тэмдэглэл: 1–2: Баталгаажуулагч нь хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй, харин тодорхой хэмжээнд ахиц гарсан гэж үзэж байна.

3: Баталгаажуулагч нь шалгуур хамааралгүй гэдэгтэй санал нийлэхгүй, харин Монгол улсыг тодорхой хэмжээнд ахиц гаргасан гэж үзэж байна.

4: Баталгаажуулагч нь Монгол улсын тодорхой хэмжээнд ахиц гаргасан төдийгүй, хангалттай гэж үзэж байна.

5: Баталгаажуулагч нь Монгол улсын үйл ажиллагааг хангалттай төдийгүй, маш сайн гэж үнэлж байна.

6: Баталгаажуулагч 7.2-т заасан шалгуурыг заавал шаардлагатай гэж үзэхгүй байна. Тийм учраас үнэлгээнд хамруулаагүй болно.

3. ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1 **Засгийн газрын оролцоо.** Бид Монгол улсын Засгийн газрын оролцоо хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй, харин **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ** гарсан гэж үзэж байна. Ажлын албаны Анхны үнэлгээнд дурьдсанаар Олон талт ажлын хэсгийн ахлагч Ноён Баабар 2016 оны 5 сарын 22-ны өдрийн ажлын хэсгийн хурал дээр иргэний нийгмийн байгууллагуудыг “гол бүрүүтнүүд” гэж нэрлэсэн бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд түүнийг “иргэний нийгмийн оролцоог боомлогч” гэж үзэж байна. Энэ нь Монгол улсын ОУИТБС-ын 1.1(с)-д тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх Засгийн газрын оролцоог сөргөөр харуулж байна. Анхны үнэлгээнд тэмдэглэснээр Олон талт ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүдийн хурлын ирц мүү, “төр, иргэний нийгмийн байгууллагын хуралд оролцох ёстой гишүүд нь оролцдоггүй, өмнөөсөө төлөөлөл явуулдаг бөгөөд төлөөлөл нь тогтмол бус, байнга өөрчлөгдөж байдаг”. Түүнчлэн улс төрийн тогтворгүй байдал нь Үндэсний зөвлөлийн хурлыг зохион байгуулахад нөлөөлж байдаг. Тухайлбал, Ерөнхий сайд, Сангийн сайд нар 2012 оноос хойш Үндэсний зөвлөлийн хуралд оролцоогүй. 2014 оны 11 сард шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор Олон талт ажлын хэсгийн даргын томилгоо таван сараар хойшлогдсоны улмаас Үндэсний зөвлөл 2014 онд хуралдаагүй. (2015 онд хоёр удаа хуралдаж нөхсөн.) “Ерөнхий сайдын ахлах зөвлөх Олон талт ажлын хэсгийн даргаар ажилладаг тул Ерөнхий сайд байнга өөрчлөгдөж байгаа нь Үндэсний зөвлөлийг удирдах, Олон талт ажлын хэсгийг хуралдуулах ажлыг байнга хойшлуулж байна.”
- 1.2 **Компанийн оролцоо.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгт санал нийлж байгаа бөгөөд Олон талт ажлын хэсэг аль болох уул уурхайн жижиг компаниудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.
- 1.3 **Иргэний нийгмийн оролцоо.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгт санал нийлж байна.
- 1.3 **Олон талт бүлгийн засаглал, үйл ажиллагаа.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ** гаргаж байгаа гэдэгтэй санал нэг байна.
- 1.4 **Ажлын төлөвлөгөө.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэж үзэж байна.

- 2.1 **Хууль эрх зйн орчин, санхүүгийн дэглэм.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэж үзэж байна.
- 2.2 **Тусгай зөвшөөрлийн хуваарилталт.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ** гаргаж байгаа гэдэгтэй санал нэг байна.
- 2.3 **Тусгай зөвшөөрлийн бүртгэл.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 2.4 **Гэрээ.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ Анхны үнэлгээнд өнөөдрийг хүртэл олон нийтэд ил болгосон маш цөөн тооны гэрээг тусгасан. ОУИБТС-ын тайланд эдгээр гэрээг хаанаас авч болохтухай мэдээллийг багтаасан боловч, үнэлгээний тайланд энэ тухай дурьдаагүй байна.
- 2.5 **Бенефициар өмчлөл.** ОУИБТС-ыг хэрэгжүүлж байгаа орнуудыг одоохондоо энэ асуудлаар тайлагнахыг шаардаагүй байгаа бөгөөд энэ нь тухайн орны ОУИБТС-ийн статустай ямар нэгэн хамаарал байхгүй.
- 2.6 **Төрийн оролцоо.** Бид энэ асуудлаар Монгол улсын хийж буй ажил **ХАНГАЛТГҮЙ** байгаа гэж дүгнэсэнтэй санал нийлж байна.
- 3.1 **Хайгуул.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 3.2 **Үйлдвэрлэл.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг бүс нутгаар нь задалж дэлгэрүүлээгүй, ялангуяа өөр өөр мэдээллийн эх үүсвэрээс авсан тоо мэдээлэл хоорондоо зөрж байна.
- 3.3 **Экспорт.** Бид энэ асуудлаар Монгол улс хангалттай ахиц гаргаж байгаа гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй, харин **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ ГАРГАЖ БАЙГАА** гэж бодож байна. Анхны үнэлгээнд Монгол улсын Ашигт малтмалын газраас гаргаж буй экспортод гаргасан ашигт малтмалын хэмжээ, үнийн мэдээллийг (бүтээгдэхүүн тус бүрээр нь) гаргаж байгаа гэж тэмдэглэсэн боловч ашигт малтмалыг олборлож байгаа аймаг, газар зүйн байрлалаар нь задалсан мэдээлэл алга байна. Экспортын тоо мэдээллийг ОУИБТС-ийн тайланд хамрагдаж буй санхүүгийн жилээр гаргах ёстой (өөрөөр хэлбэл тэр жилийн экспортын мэдээ) боловч Ашигт малтмалын газраас гаргасан статистик мэдээнд зөвхөн тухайн жилд үйлдвэрлэгдэж, экспортлогдсон ашигт малтмалын мэдээ байгаа бөгөөд тухайн жилд экспортолсон зарим бүтээгдэхүүнийг оруулаагүй байна. Анхны үнэлгээнд тулгуурлан дүгнэхэд Монгол улс энэ шаардлагын *ихэнхийг* хэрэгжүүлж байгаа боловч бүрэн хэрэгжилтийг хангаж чадаагүй байна (Дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж, ялангуяа мэдээллийг ашигт малтмал тус бүрээр нь задлан, хаанаас олборлосон тухай мэдээллийг ил тод болгох ёстой.)
- 4.1 **Татвар, орлогын тухай дэлгэрэнгүй мэдээлэл.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 4.2 **Улсын эзэмшлийн хувьцааг зарж борлуулах, эсвэл хандивын орлогыг авсан байдал.** Энэ асуудал Монгол улсад хамаарахгүй гэдэгтэй санал нийлэхгүй байна. Газрын тосыг төр өөрөө борлуулаагүй, төрийн өмнөөс өөр этгээд борлуулсан тохиолдолд газрын тосны борлуулалтын орлогоос төрийн авах хувийг 4.2-т заасан шаардлагын дагуу ОУИБТС-ын тайланд тусгаагүй, түүнийг нь Анхны үнэлгээгээр хүлээн зөвшөөрсөнтэй санал нийлэхгүй байна. 4.2-р зүйлд заасны дагуу борлуулалтын хэмжээ, үнэ, төлсөн төлбөрийн талаарх

мэдээллийг борлуулалтыг төр биш, өөр этгээд хийж гүйцэтгэсэн ч тайланд тусгах ёстой. Энэ борлуулалтын орлогын талаарх мэдээллийг ил тод болгож, тайланд тусгасан боловч борлуулалтын хэмжээг бүрэн тусгаагүй учраас энэ заалтыг бид **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ ГАРЧ БАЙГАА** гэж үнэлэх байна.

- 4.3 **Дэд бүтэц, бартерын асуудлаар.** Одоогоор Монгол улсад хамаарахгүй. Эдгээр асуудлыг ярилцсаны үндсэн дээр одоохондоо хэрэглэхгүй гэж шийдсэн.
- 4.4 **Тээвэрлэлтийн орлого.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна. 4.4-т заасан шаардлагын дагуу ОУИТБС-ын тайланд Олон талт ажлын хэсгээс тээвэрлэлтийн орлогыг ил тод болгох, ил тод болгоогүй, эсвэл хагас дутуу ил болгож байгаагийн шалтгааныг тусгасан байна.
- 4.5 **Төрийн өмчит үйлдвэрийн газруудтай холбоотой гүйлгээ.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ ГАРГАЖ** байгаа гэдэгтэй санал нэг байна.
- 4.6 **Орон нутгийн төлбөр.** Энэ асуудлаар Монгол улс тодорхой хэмжээнд ахиц гарч байгаа төдийгүй **ХАНГАЛТТАЙ** үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Анхны үнэлгээний тайланд дурьдсаны дагуу Олон талт ажлын хэсэг нь орон нутагт төлбөр хийгдэж байгаа есөн жишээг сонгож аваад мэдээллийг нээлттэй болгох, дэлгэрэнгүй мэдээлэх, нэгтгэх арга хэмжээ авлаа. Энэ нь Анхны үнэлгээнд Төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2.6 - 6.2 хүртэлх шаардлагуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг нилээд сайн гаргаж тавьсан байна.
- 4.7 **Мэдээллийн задаргаа.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ мэдээллийг төслийн түвшинд дэлгэрүүлж, задаргаатай ирүүлэх талаар ярилцаж байгаа боловч АНУ-ын SEC дүрэм болон удахгүй хэрэгжих Европын холбооны стандартын дагуу мэдээлэл ирдэггүй.
- 4.8 **Мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 4.9 **Мэдээллийн чанар, баталгаат байдал.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ ГАРГАЖ** байгаа гэдэгтэй санал нийлж байна. Тайлан гаргаж байгаа төрийн байгууллага, компаниудын ихэнхи нь мэдээллийн чанарын баталгааны журмыг мөрдөхгүй, аль ч компаниас шаардсан ёсоор чанарын баталгааны хязгаарлалтын тухай дүгнэлт ирээгүй байгаа нь анхаарал татууштай.
- 5.1 **Олборлох үйлдвэрлэлийн орлогын хуваарилалт.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 5.2 **Орон нутгийн шилжүүлэг.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ ГАРГАЖ** байгаа гэдэгтэй санал нэг байна.
- 5.3 **Орлогын удирдлага, зарцуулалт.** Энэ талаар тайлагнахыг дэмжиж байгаа боловч заавал тайлагнах шаардлагагүй учраас нийт үнэлгээний дүнг тооцохдоо харгалзаж үзээгүй болно.
- 6.1 **Уул уурхайн компаниудаас зарцуулж буй нийгмийн зардал.** Анхны үнэлгээний тайланд дурьдсан шалтгаанаар заавал зарцуулах нийгмийн зардлыг бүрэн тайлагнаж байх талаар Монгол улс **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ** гаргаж байгаа гэдэгтэй санал нэг байна.

Нийгмийн зардлыг сайн дурын үндсэн дээр тайлагнахыг дэмжиж байгаа бөгөөд Монгол улсын түвшинг үнэлэхэд ашиглаагүй болно.

- 6.2 **Төсвийн шинжтэй санхүүгийн зардал.** Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТГҮЙ** ажиллаж байгаа гэдэгтэй санал нэг байна.
- 6.3 **Олборлох үйлдвэрлэлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр.** Бид энэ асуудлаар, ялангуяа хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг харвал, Монгол улс **МАШ САЙН** ахиц гаргасан гэдэгтэй санал нэг байна.
- 7.1 **Олон нийтийн хэлэлцүүлэг.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна. Ялангуяа, орон утгийн түвшинд олон талт ажлын хэсэг байгуулсан, орон нутгийн түвшинд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан зэрэг нь дэмжүүштэй боловч тэдгээрийг илүү албан ёсны байдлаар зохион байгуулан, үндэсний түвшний ОУИТБС-ын хэлэлцүүлэгт албан ёсоор оролцуулах механизмыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.
- 7.2 **Мэдээллийн хүртээмж.** Энэ асуудлыг дэмжиж байгаа боловч зайлшгүй шаардлагатай биш. Тийм учраас үнэлгээ хийхдээ харгалзаж үзээгүй болно.
- 7.3 **Сургамж ба зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал.** Бид Монгол улс энэ асуудлаар **ХАНГАЛТТАЙ** ахиц гаргаж байгаа гэдэгтэй санал нийлж байна.
- 7.4 **ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн, нөлөө.** Бид Монгол улс энэ асуудлаар **ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД АХИЦ** гаргаж байгаа гэдэгтэй санал нэг байна.

4. ЗӨВЛӨМЖ

Ажлын албанаас Монгол улсад ОУИТБС-ын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн дараахь зөвлөмжийг Баталгаажуулалтын багаас хийсэн өөрчлөлт, нэмэлтийн хамт хүргүүлж байна. Баталгаажуулалтын багийн нэмсэн, өөрчилсөн хэсгийг налуу үсгээр бичсэн болно.

- 4.1 *Засгийн газраас Олон талт ажлын хэсгийн даргыг томилохдоо бүх оролцогч талуудын хүндлэлийг хүлээсэн, ОУИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн, идэвхитэй, үр дүнтэй оролцох хүнийг олж томилох нь зүйтэй. Засгийн газар нь (1) өөрийн төлөөллийг Олон талт ажлын хэсэг болон Үндэсний зөвлөлийн хуралд байнга тогтвортой оролцуулах, (2) Олон талт ажлын хэсгийн үйл ажиллагааг сонгууль, улс төрийн нөхцөл байдлаас үл хамааран үргэлжлүүлэх арга тогтолцоог бий болгох зэрэг тодорхой журмыг тохиролцох хэрэгтэй.*
- 4.2 ОУИТБС-ын засаглалын бүтэц, бүрэлдэхүүнийг дахин хянаж үзэн, ялангуяа ажлын уулзалтын тоог нэмэгдүүлэн, түүнд ажиллаж байгаа гишүүийн тоог цөөрүүлж, ажлын хэсэг дээр ярилцсан зүйлийг түгээж, тараахад анхаарал хандуулах хэрэгтэй (Үүнд албан бус уулзалтууд бас багтана).
- 4.3 Оролцогч гурван тал олборлох үйлдвэрлэлийн ямар асуудлуудыг ОУИТБС-д тусгах, яаж тусгах талаар ярилцах хэрэгтэй. Ингэснээр ОУИТБС-ын зорилго бүрэн тодорхойлогдож, түүний хүрээнд ажлын төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах боломжтой болно.
- 4.4 Олон талт ажлын хэсгийн хэлэлцэж буй асуудлыг үндэсний түвшинд хэлэлцүүлэх, олон талт ажлын хэсэгт шууд орж ажиллаж чадахгүй байгаа талуудын байр суурийг харгалзаж үзэхийн

тулд оролцогч талуудын зөвлөлдөх механизмыг дахин хянаж үзэн, албажуулах хэрэгтэй.

4.5 Нэг талаас мэдээллийг дэлгэрэнгүй гаргах, нөгөө талаас мэдээллийн чанарыг хангахын тулд Олон талт ажлын хэсгээс ямар мэдээллийг тайлагнах, ямар мэдээллийг тайлагнахгүй болохыг (үүнд хандив, тээврийн орлого, бартер, дэд бүтцийн гүйлгээ зэрэг багтана) тодорхой болгох шаардлагатай байна. Олон талт ажлын хэсэг нь Анхдагч үнэлгээнд хавсаргасан мэдээлэл цуглуулах маягыг ашиглан Статистикийн ерөнхий газартай мэдээлэл цуглуулах журмаа тохиролцох хэрэгтэй. Түүнчлэн, олон талт ажлын хэсэг хараат бус нэгтгэгчээр дараагийн ОУИТБС-ын тайлангийн цогц байдалд дүгнэлт хийлгэх хэрэгтэй.

4.6 *Монгол улс нь ОУИТБС-ын стандартын 3.3-т заасны дагуу ашигт малтмал, газрын тосны экспортын хэмжээ, үнийг бүсээр, эсвэл аймгаар задалж тайлагнах хэрэгтэй.*

4.7 Олон талт ажлын хэсэг, хараат бус нэгтгэгч нь 2016 оны санхүүгийн жилийг хамарсан ОУИТБС-ын тайланг гаргахдаа Засгийн газар, аж ахуйн нэгж байгууллагуудын ОУИТБС-ын хүрээнд ил тод болгож байгаа мэдээллийн чанарын баталгааг хангасан идэвхитэй, прагматик арга боловсруулж, хэрэглэх нь зүйтэй. Олон талт ажлын хэсэг нь Үндэсний аудитын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, хараат бус нэгтгэгч, салбарын олон талт ажлын хэсгийн гишүүдтэй мэдээллийн чанарын баталгааны асуудлаар хамтарч ажиллах хэрэгтэй. Олон талт ажлын хэсэг нь дараагийн тайлан дээр ажиллах хараат бус нэгтгэгчийг аль болох эртхэн сонгон шалгаруулж, мэдээлэл цуглуулах цаг хугацаа, боломж олгох хэрэгтэй.

4.8 Дараагийн ОУИТБС-ын тайланд Олон талт ажлын хэсгээс уул уурхай, газрын тос, байгалийн хийн хичнээн тусгай зөвшөөрөл олгогдсон, шилжүүлсэн тухай мэдээллийг оруулж заавал мөрдөх журмаас гадуур олгогдсон тохиолдол байгаа эсэхэд анхаарал хандуулна. Түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн огноог ОУИТБС-ын дараагийн тайлан хэвлэгдэхээс өмнө олон нийтэд ил тод болгоно. Засгийн газар энэ мэдээллийг тусгай зөвшөөрлийн онлайн системээрээ дамжуулан олон нийтэд мэдээлж болно.

4.9 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланг бэлтгэхдээ төрөөс бенефициар өмчлөлийн талаар баримталж байгаа бодлогын талаар тодорхой оруулж, хуулийн эзэмшлийн талаарх мэдээллийг тусгана.

4.10 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланг бэлтгэхдээ уул уурхай, газрын тос байгалийн хийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн өмчит улсын үйлдвэрийн газруудын орлого тушаасны дараахь үлдэгдэл, дахин хөрөнгө оруулалт, төрийн өмчийн эзэмшилд гарсан өөрчлөлт, авсан зээл, зээлийн баталгааны талаар мэдээллийг бүрэн тусгах хэрэгтэй. Олон талт ажлын хэсэг нь төрөөс уул уурхайн салбарт үзүүлж буй татаас, олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа төрийн өмчит улсын үйлдвэрийн газруудын төсвийн шинжтэй санхүүгийн зарцуулалтын талаарх мэдээллийг оруулах нь зүйтэй.

4.11 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланд хараат бус нэгтгэгчийн хийх (санхүүгийн) мэдээллийн дэлгэрэнгүй ба найдвартай байдлын дүн шинжилгээг тусгаж, түүндээ хараат бус нэгтгэгч дүн шинжилгээ хийхдээ ямар ажил гүйцэтгэсэн, ингэхдээ ямар бэрхшээлтэй тулгарсан тухай тэмдэглэнэ.

4.12 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланд төрийн өмчит улсын үйлдвэрийн газраас шилжүүлж буй орон нутгийн шууд төлбөр, шилжүүлэг хоёрын хоорондын ялгааг тодруулах хэрэгтэй. Түүнчлэн аймаг, суманд хуваарилж буй шилжүүлгийн төлөвлөгөө,

гүйцэтгэл хоёрыг харьцуулахын тулд шилжүүлгийг тооцож буй орлогын хуваарилалтын томъёог тайланд тусгах хэрэгтэй.

- 4.13 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланд заавал төлөх болон сайн дурын нийгмийн зардлын ялгааг тайлбарлана. Түүнчлэн, заавал төлөх нийгмийн зардлаас хүртэж буй төрийн бус ашиг хүртэгчтэй хэрхэн харилцдаг талаарх мэдэллийг оруулах нь зүйтэй.
- 4.14 Монгол улсад социал медиа өндөр хөгжсөн байна. Үүнтэй холбоотойгоор олон талт ажлын хэсгээс ОУИТБС-тай холбоотой олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, мэдээлэл түгээх, олон талт ажлын хэсгийн төлөвлөгөө, жилийн тайлан зэргийг хэлэлцүүлэхдээ аль болох олон хүнийг оролцуулах зорилгоор социал медиаг ашиглаж болох эсэхийг харгалзаж үзнэ.
- 4.15 Олон талт ажлын хэсэг нь ОУИТБС-ын дараагийн тайланг бэлтгэхдээ ОУИТБС-ын нөлөө үр дүн, зөвлөмжийн хэрэгжилт зэргийг оролцогч талын өргөн оролцоотойгоор хэлэлцэж, үнэлгээ хийнэ. Олон талт ажлын хэсгээс ОУИТБС-ын тайланд тусгах зөвлөмжийг боловсруулах, түүний хэрэгжилтийг хянахад идэвхитэй оролцох хэрэгтэй.
- 4.16 Олон талт ажлын хэсэг нь Засгийн газрын зүгээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг цаашид бэхжүүлэхийг дэмжин, ОУИТБС-ын мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол хэвлүүлэхэд анхаарч ажиллана. И-тайлан төслийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэхдээ ОУИТБС-ын стандартын дагуу ямар мэдээллийг ил тод болгох шаардлагатай байгаа талаар судалгаа хийж, ямар мэдээлэл нь одоо ил тод байгаа, ямар мэдээллийг ил тод болгох шаардлагатай байгааг тодорхойлно. ОУИТБС-ын хүрээнд аль болох их мэдээллийг тайлагнах зорилгоор тайлангийн маягтуудыг нээлттэй болгох асуудалд анхаарах хэрэгтэй.
